



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/2021

Бат-Өлзий сум

Гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5.2, 4.5.3, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Зөрүүлэг багийн Намгийн булгийн эх хаших, Онгоцотын эхэн булгийн эх хаших, Бүрдний булгийн эх хаших ажлыг 4 дүгээр багийн иргэн Б.Чимэд-Очиртой шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлсүгэй.

2. 4 дүгээр багийн иргэн Б.Чимэд-Очиртой гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Зөрүүлэг багийн Намгийн булгийн эх хаших, Онгоцотын эхэн булгийн эх хаших, Бүрдний булгийн эх хаших ажилд шаардагдах 11,900,000 (арван нэгэн сая есөн зуун мянга) төгрөгийг гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн Малын тоо толгойн албан татварын бусад хөрөнгө зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН

